

Агаарын температур °C (Үнэмлэхүй их/бага)



Тохиолдсон аюулт үзэгдэл, осол

Байгалийн болон геологийн гаралтай аюулт үзэгдэл



* Дахин их

Хүний үйл ажиллагаатай холбоотой осол



Биологийн гаралтай аюулт үзэгдэл



2/2021

Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 12




Үнэмлэхүй бага температур 2021 оны 2 дугаар сард Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд – 40.5 °C-д хүрсэн байна

Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 2 дугаар сард Өмнөговь аймгийн Манлай суманд +16.6°C, үнэмлэхүй бага температур Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд -40.5°C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖТАЙ¹ ХАРЬЦУУЛСНААР, станцын байршлаар, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар



¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 2 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Дорнод аймгийн Дашбалбар суманд 9.8 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Ховд аймгийн Зэрэг сумын нутгаар түр зуур 32 м/с-д хүрсэн байна. Цасны үнэмлэхүй их зузаан 2021 оны 2 дугаар сарын 28-ны байдлаар Хөвсгөл аймгийн Цагааннуур суманд 20.0 см байжээ.

Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын дундаж агууламж 2021 оны 2 дугаар сард бүх станцуудад 0.048 мг/м³ – 0.226 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.014 мг/м³ – 0.176 мг/м³-ээр давсан байна.


Харин азотын давхар ислийн сарын дундаж агууламж 2021 оны 2 дугаар сард Баруун дөрвөн зам орчимд 0.060 мг/м³-д хүрч агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.010 мг/м³-ээр, 1-р хороолол болон 13-р хороолол орчимд 0.055 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.005 мг/м³-ээр тус тус давсан байна.

Харин Хархорин зах орчимд 0.050 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжийн түвшинд байсан байна.


PM 2.5 тоосонцрын сарын дундаж агууламж (агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан станцуудын хувьд) 2021 оны 2 дугаар сард Хайлааст орчимд хамгийн их буюу 0.106 мг/м³-д хүрсэн нь агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.056 мг/м³-ээр давсан бол 13-р хороолол, Амгалан орчимд хамгийн бага буюу 0.051 мг/м³-д хүрч агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.001 мг/м³-ээр давсан байна.

PM 10 тоосонцрын сарын дундаж агууламж (агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан станцуудын хувьд) 2021 оны 2 дугаар сард Баянхошуу орчимд хамгийн их буюу 0.148 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.048 мг/м³-ээр давсан бол 13-р хороолол орчимд хамгийн бага буюу 0.104 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.004 мг/м³-ээр давсан байна.


ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ ХҮХЭРЛЭГ ХИЙН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мг/м³



ЗУРАГ 3. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ PM 2.5 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³




ЗУРАГ 4. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ РМ 10 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³



Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын дундаж агууламжийг авч үзвэл, 2021 оны 2 дугаар сард азотын давхар исэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.017 мг/м³ (29.4%)-ээр, РМ 2.5 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.005 мг/м³ (7.1%)-ээр тус тус бага байсан бол хүхэрлэг хий өмнөх оны мөн үеэс 0.062 мг/м³ (81.0%), РМ 10 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.001 мг/м³ (1.3%)-ээр тус тус их байна.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 2 дугаар сарын байдлаар, мг/м³



ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станцаар, 2021 оны 2 дугаар сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоос (PM10)	Тоос (PM2.5)
Мишээл экспо	19	3	-	3	-
Баруун 4 зам	18	19	-	15	16
1-р хороолол	19	14	4	20	22
13-р хороолол	24	15	-	14	15
32-ын тойрог	28	4	-	16	-
Хархорин	24	13	-	18	-
Ургах наран хороолол	16	13	-	13	-
Хайлааст	27	-	-	14	24
248-р цэцэрлэг	27	10	-	6	9
Богд хааны ордон музей	10	1	-	4	3
Нисэх	26	8	-		8
Толгойт	-	-	5	2	16
Зурагт	28	11	2	11	24
Амгалан	21	6	-	5	11
Баянхошуу	19	-	-	16	-

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 2 сард 752 болж, өмнөх оны мөн үеэс 43 (6.1%) аар өссөн байна. Объектын түймэр 474 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 105 (18.1%) иар буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 2 сард мал, амьтны халдварт галзуу өвчний 5, шинэ төрлийн Корона вирус (Covid-19) халдварын 1692 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн эхний 2 сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-II	2019 I-II	2020 I-II	2021 I-II	$\frac{2021 \text{ I-II}}{2020 \text{ I-II}} \%$
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	тоо	819	509	709	752	106.1
Амь насаа алдсан хүн	тоо	20	17	33	47	142.4
Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн	тоо	23	3	15	1 719	114.6 ¹
Шатсан гэр, орон сууц	тоо	319	251	346	145	41.9
Объектын түймэр	тоо	723	431	579	474	81.9
Учирсан хохирол	тэрбум төгрөг	8.4	2.3	3.1	2.4	77.4
Зарцуулсан зардал	сая төгрөг	334.8	107.8	43.1	36.4	84.5

¹ - Дахин их

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 2 сард нийт 47 хүн амь насаа алдаж, 1719 хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон байна.

Амь насаа алдсан шалтгааныг нь авч үзэхэд объектын түймрийн улмаас 22 хүн, бичил уурхай, нурангийн улмаас 1 хүн, бусад золгүй явдлын улмаас 24 хүн амь насаа алджээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 2 сард 145 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 201 (58.1%)-ээр буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 2 сард 2.4 тэрбум төгрөгийн хохирол учирч, 36.4 сая төгрөг зарцуулсан байна.

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны эхний 2 сард 220 хүнийг аварч, 11.4 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 15



Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Д.Баасан
Утас : (976-51)-261502